



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 27 (360)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Бөхчүүдэд улсын харцага цол олгох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Хорио цээрийн дэглэм, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг цуцлах тухай*
- *Хамгаалалтын бүс тогтоох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2004 оны дэлдугаар сарын 12

№27 (360)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

314.	Бөхчүүдэд улсын харцага цол олгох тухай	Дугаар 102	644
315.	Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 107	645
316.	Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 108	645
317.	Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 109	645

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

318.	Бүтэц батлах тухай	Дугаар 96	645
319.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 108	649
320.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 123	652
321.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 124	652
322.	Хорио цээрийн дэглэм, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг цуцлах тухай	Дугаар 125	653
323.	Хамгаалалтын бүс тогтоох тухай	Дугаар 126	654

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 6 дугаар сарын 22 -ны өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

Бөхчүүдэд улсын харцага цол олгох тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйл, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Үндэсний их баяр наадамд зургаа давсан дор дурдсан бөхчүүдэд улсын харцага цол олгосугай.

1.Жарантайн Авхиа
Говь-Алтай аймгийн Шарга сумын харьяат, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Спорт сургалтын төвийн бөх

14.Тэрбишийн Нармандах
Завхан аймгийн Цагаанчулуут сумын харьяат, "Хүч" спорт хорооны бөх

2.Арцын Гончиг
Архангай аймгийн Жаргалант сумын харьяат, Архангай аймгийн Спорт хорооны бөх

15.Чогжинмүнсэлийн Даваадорж
Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын харьяат, "Хүч" спорт хорооны бөх

3.Ишийн Ламаажав
Өмнөговь аймгийн Булган сумын харьяат, Өмнөговь аймгийн Спорт хорооны бөх

16.Монхорын Дармаабазар
Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын харьяат, Завхан аймгийн Спорт хорооны бөх

4.Данзандаржаагийн Сэрээтэр
Төв аймгийн Лун сумын харьяат, Боловсролын их сургуулийн харьяа БТДС-ийн бөх

17.Жанчивравдангийн Намжилдорж
Төв аймгийн Баянцагаан сумын харьяат, УБТЗ-ын "Есөн туг" дэвжээний бөх

5.Чойдорын Өвгөнхүү
Сүхбаатар аймгийн Уулбаян сумын харьяат, "Алдар" спорт хорооны бөх

18.Нарангэрэлийн Саранцогт
Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын харьяат, "Хангарьд" дэвжээний бөх

6.Цэвээнжавын Юүвээ
Архангай аймгийн Хотонт сумын харьяат, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Спорт сургалтын төвийн бөх

19.Цэдэндамбын Бэгэсүрэн
Завхан аймгийн Цагаанчулуут сумын харьяат, УБТЗ-ын "Есөн туг" дэвжээний бөх

7.Дахын Одсүрэн
Сүхбаатар аймгийн Онгон сумын харьяат, Нийслэлийн Багануур дүүргийн Спорт сургалтын төвийн бөх

20.Нинжээгийн Алтансүх
Архангай аймгийн Батцэнгэл сумын харьяат, "Хүч" спорт хорооны бөх

8.Далайцэрэнгийн Лхагва-Очир
Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын харьяат, "Хүч" спорт хорооны бөх

21.Чойнхорын Чулуунбаатар
Увс аймгийн Тэс сумын харьяат, "Хүч" спорт хорооны бөх

9.Однойн Бахыт
Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын харьяат, Баян-Өлгий аймгийн Спорт хорооны бөх

22.Гунгаагийн Элбэг
Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын харьяат, "Идэр хөлдэнг" ХХК-ийн бөх

10.Жамцын Бор
Булган аймгийн Орхон сумын харьяат, Булган аймгийн Спорт хорооны бөх

23.Цэдэвийн Мягмарсүрэн
Ховд аймгийн Мест сумын харьяат, "Хүч" спорт хорооны бөх

11.Болдын Жавхлантөгс
Архангай аймгийн Батцэнгэл сумын харьяат, "Алдар" спорт хорооны бөх

24.Ганзоригийн Ганхуяг
Хөвсгөл аймгийн Галт сумын харьяат, "Монгол газар" дэвжээний бөх

12.Лүндэгийн Бадарч
Төв аймгийн Баянцагаан сумын харьяат, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Спорт сургалтын төвийн бөх

25.Гэлэгжамцын Батбаяр
Архангай аймгийн Батцэнгэл сумын харьяат, "Хилчин" дэвжээний бөх

13.Гэлэгийн Намсрайжав
Увс аймгийн Ховд сумын харьяат, Нийслэлийн Баянгол дүүргийн Спорт сургалтын төвийн бөх

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 6 дугаар сарын 30 -ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөрөө хүсэлт гаргасан Цэвээндоржийн Алтанцэцэгийг Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгчийн, Шаравын Оюунхандыг Ховд аймаг дахь

сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 6 дугаар сарын 30 -ны өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цэвээндоржийн Алтанцэцэгийг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн,

Шаравын Оюунхандыг Багануур дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 6 дугаар сарын 30 -ны өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй тухай Шүүхийн мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан тул Лүүрэвийн Жавзмааг Увс аймгийн шүүхийн шүүгчийн, Батхишигийн

Баттулгыг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Дамдинкамцын Буянтогтохыг Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Бүтэц батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын удирдлага, зохион байгуулалтын бүтцийг хавсралт ёсоор баталсугай.

2. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх чиг үүрэг бүхий Ядуурлын судалгааны нэгжийг хавсралтад заасан орон тоогоор яамныхаа бүтцэд шилжүүлэн ажиллуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Яамдын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2003 оны 43 дугаар тогтоолын "1.2. Санхүү, эдийн засгийн яам -Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар" гэсэн хэсэгт (Ядуурлын судалгааны нэгж) гэж нэмэлт оруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД

Ч.УЛААН

Засгийн газрын 2004 оны 96 дугаар тогтоолын хавсралт

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИЖ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ АЖЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Засгийн газар Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын удирдлага, зохион байгуулалтын бүтцийн зорилго нь хөгжлийн үр дүнд үнэлгээ өгөх, ялангуяа Мянганы хөгжлийн зорилттой уялдуулах, бодлогод өөрчлөлт оруулах боломжит хувилбаруудыг тодорхойлох, мэдээлэхэд оршино.

Хоёр. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын удирдлага, зохион байгуулалтын бүтцийн тогтолцоо

2.1. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо нь Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн жил бүрийн явцын тайланг бэлтгэж гаргахад чиглэгдэнэ. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратеги нь 3 жил


тутамд шинэчлэгдэх бөгөөд 2006 он гэхэд 2007-2009 оныг хамарсан Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хоёрдугаар үе шат бэлтгэгдсэн байна.

2.2. Стратегийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо нь "Стратегийн удирдлага" ба "Мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ"-ний гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ (Хүснэгт-1).

2.2.1. Стратегийн удирдлагын хэсгийн үйл ажиллагааны чиглэл:

- 1/Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцын тайланг бэлтгэх;
- 2/Стратегийг шинэчлэн сайжруулах;
- 3/Тайлангийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулах;
- 4/Засгийн газарт тайлагнах;
- 5/Тайланг холбогдох этгээдүүдэд хүргүүлэх.

Хүснэгт 1: Удирдлага, зохион байгуулалтын бүтэц:



2.2.2. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээний хэсгийн үйл ажиллагааны чиглэл:

1/Чанарын болон тоон үзүүлэлтүүд ялангуяа төсвийн гүйцэтгэл, үр дүнгийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг хамарсан Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл цуглуулах;

2/Дүн шинжилгээ хийх;

3/Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн явцын тайланг бэлтгэхэд стратегийн удирдлагын хэсгийг холбогдох мэдээллээр хангах.

Гурав. Стратегийн удирдлагын хэсэг

3.1. Стратегийн удирдлагын хэсэг нь Санхүү эдийн засгийн яам, Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн бодлогын зөвлөл, Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн бодлогын салбар зөвлөлүүд, Үндэсний болон бүсийн зөвлөлдөх уулзалт зэргээс бүрдэнэ. Тэдгээрийн гишүүнчлэл болон үүрэг дор дурдсанаар байна. Үүнд:

3.1.1. Санхүү, эдийн засгийн яам: Санхүү, эдийн засгийн яам нь Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцын тайланг Засгийн газарт жил бүр танилцуулна.

3.1.2. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн бодлогын зөвлөл: Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн бодлогын зөвлөлийг орон тооны бус хэргээр Ерөнхий сайдын захирамжаар байгуулж ажиллуулна.

3.1.2.1. Бодлогын зөвлөл нь дор дурдсан үүрэгтэй байна:

1/Оролцогч талуудаас бэлтгэсэн мэдээлэлд тугуурлан Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцын тайланг бэлтгэх, стратегийг шинэчлэх;

2/Үндэсний болон бүсийн түвшинд зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах ба уулзалтаас гарсан санал зөвлөмжийг Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцын тайланд тусгах;

3/Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцын тайланг Санхүү, эдийн засгийн яамаар дамжуулан Засгийн газарт танилцуулах;

4/Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцын

тайлан болон холбогдох бусад мэдээллийг бусад этгээдүүдэд хүргүүлэх.

3.1.3. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн бодлогын зөвлөл нь макро эдийн засаг, бодит салбар, хүний хөгжил ба бодлогын салбар зөвлөлүүдтэй нийгэм, Бүсийн хөгжил ба байгаль орчин, Засаглал гэсэн чиглэлээр байна. Эдгээр нь орон тооны бус байх бөгөөд бодлогын зөвлөлийн даргын шийдвэрээр байгуулагдана. Салбар зөвлөл нь Санхүү, эдийн засгийн яам болон холбогдох бусад салбар яамд, Орон нутгийн засаг захиргаа, хандивлагчид (гишүүнийг хандивлагчид өөрсдөө сонгоно) болон Төрийн бус байгууллага (гишүүнийг Төрийн бус байгууллагын ажлын хэсгээс сонгон)-ын болон бусад салбар чиглэлийн ажлын хэсгийн төлөөллөөс бүрдэнэ.

3.1.4. Бодлогын салбар зөвлөлүүд нь дор дурдсан үүрэгтэй байна:

1/Тухайн салбарын чиглэлээр Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцын тайлан бэлтгэх;

2/Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн бодлогын зөвлөл санал, зөвлөмж өгөх;

3/Холбогдох чиглэлийн хяналт-шинжилгээний үр дүнгийн үзүүлэлтийн жагсаалтыг шинэчлэх, сайжруулах.

3.1.5. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн бодлогын зөвлөл нь үндэсний зөвлөлдөх уулзалтыг жил бүр зохион байгуулна. Үндэсний зөвлөлдөх уулзалтанд төр, засгийн байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа болон хандивлагчдын төлөөлөгчид оролцоно. Үндэсний зөвлөлдөх уулзалт нь Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн бодлогын зөвлөлөөс бэлтгэн гаргасан Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцын тайланг хэлэлцэнэ.

3.1.6. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн бодлогын зөвлөл нь Бүсийн зөвлөлдөх уулзалтыг жил бүр зохион байгуулна. Бүсийн зөвлөлдөх уулзалтанд төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, хандивлагчдын төлөөлөгчид оролцоно. Бүсийн зөвлөлдөх уулзалт нь Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн бодлогын зөвлөлөөс бэлтгэн гаргасан Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцын тайланг хэлэлцэнэ.

Дөрөв. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх хэсэг

4.1. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх хэсэг нь Ядуурлын судалгааны үзг, Үндэсний статистикийн газар, салбар яамдын (яналт шинжилгээ, үнэлгээний газар, хэлтсүүд, ймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын (олбогдох мэргэжилтэн, Санхүү, эдийн засгийн яамны Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар, Төсвийн бодлого, зохицуулалтын газар, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, хандивлагчид болон Мэдээлэл Боловсруулагч-хэрэглэгчдийн бүлгээс бүрдэнэ. Эдгээр байгууллагуудын гишүүнчлэл болон үүрэг нь дор дурдсанаар байна:

4.1.1. Ядуурлын судалгааны нэгж нь Санхүү, эдийн засгийн яамны Эдийн засгийн нэгдсэн Бодлого, төлөвлөлтийн газарт багтаж ажиллана. Ядуурлын судалгааны нэгжид макро эдийн засгийн, төсвийн шинжилгээний, ядуурлын үнэлгээний, нийгмийн хамгааллын, жендэрийн дүн шинжилгээний, мэдээллийн гэсэн нийт 6 орон тоо бүхий мэргэжилтэн ажиллах болно.

4.1.1.2. Ядуурлын судалгааны нэгж нь дор дурдсан үүрэгтэй байна:

1/ Мянганы хөгжлийн зорилттой уялдуулан Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцын тайлан бэлтгэх, агуулгыг тодорхойлох;

2/ Шаардагдах мэдээлэл авах маяг боловсруулах;

3/ Мэдээлэл боловсруулагчдаас гаргасан мэдээллүүдийг нэгтгэн хянаж, дүн шинжилгээ хийж, салбар зөвлөлд танилцуулах;

4/ Тухайлсан судалгааг гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах, судалгааны үр дүнд үндэслэн бодлогын зөвлөмж боловсруулах;

5/ Стратегийн хэрэгжилтийн тайланг бэлтгэн бодлогын болон салбар зөвлөлүүдээр хэлэлцүүлэх, холбогдох уулзалтуудыг зохион байгуулах, санал авах, эргэж мэдээлэх;

6/ Мэдээлэл боловсруулагч-хэрэглэгчдийн бүлгийг зохион байгуулах, тэдний гаргасан саналыг салбар зөвлөлд танилцуулах;

7/ Бодлогын зөвлөл Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцын тайланг Үндэсний болон Бүсийн зөвлөлдөх уулзалтаар хэлэлцүүлэх ажилд туслалцаа үзүүлэх;

8/ Ядуурал, нийгмийн чиглэлийн мэдээлэл цуглуулж, мэдээллийн санг баяжуулах. Хэвлэл мэдээлэл, Төрийн бус байгууллагуудын

ажлын хэсэг болон бусад сувгаар үр дүнг тархаах ажлыг бэлтгэх, тодорхой хугацаанд мэдээлэл боловсруулан хэвлүүлэх зэрэг нийтлэг үүрэгтэй байна.

4.1.2. Үндэсний статистикийн газар нь Ядуурлын судалгааны нэгжид Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу холбогдох мэдээллийг боловсруулж өгөх, Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн үзүүлэлтүүдийн мэдээллийн сан байгуулах, олон нийтийг зөв мэдээллээр хангах зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

4.1.3. Салбар яамд болон орон нутгийн засаг захиргааны хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжид салбар яамд болон орон нутгийн засаг захиргааны хяналт-шинжилгээ үнэлгээний газар, хэлтэс, мэргэжилтэнүүд, түүнчлэн Санхүү, эдийн засгийн яамны Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн болон Төсвийн бодлого, зохицуулалтын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс багтана. Дээрх байгууллагууд нь батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Ядуурлын судалгааны нэгжийг холбогдох мэдээллээр хангана.

4.1.4. Иргэний нийгэм, хандивлагчид, судлаачид, бусад мэдээлэл боловсруулагчид буюу энэ бүлэгт иргэний нийгмийн төлөөлөгчид, хандивлагчид, судалгааны байгууллагууд, хувийн хэвшлийн зөвлөгөө өгдөг байгууллагууд, бусад мэдээлэл боловсруулагчид, судлаачид оролцоно. Эдгээр байгууллагууд нь батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүдийн жагсаалтын хүрээнд холбогдох мэдээллээр хангах, Ядуурлын судалгааны нэгжээс зарласан сэдвийн дагуу судалгаа хийнэ.

4.1.5. Ядуурлын судалгааны нэгж нь тогтмол ажиллагаатай мэдээлэл боловсруулагч-хэрэглэгчдийн бүлгийг зохион байгуулна. Тус бүлэг нь орон тооны бус бөгөөд мэдээлэл боловсруулагч-хэрэглэгчид, Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн бодлогын болон салбар зөвлөлүүд, Ядуурлын судалгааны нэгж, Үндэсний статистикийн газар, салбар яамд болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний газар, хэлтсүүд, иргэний нийгэм, хандивлагчид, судалгаа, шинжилгээ, зөвлөгөө өгдөг байгууллагууд зэрэг бүхий л төлөөлөөс бүрдэнэ.

4.1.5.1. Мэдээлэл боловсруулагч-хэрэглэгчийн бүлэг нь дор дурдсан үүрэгтэй байна:

1/ Мэдээллийн зөрүү болон давхардлыг арилгах;

2/ Шаардлагатай мэдээллийг нийлүүлэх арга замыг тодорхойлох.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 5-ны өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ 23-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор баталсан "Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт"-д дор дурдсан нэмэлт оруулсугай:

Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын

201.

Дурсгалын нэр:	Очирдара
Зохиогч:	Г.Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг:	ХҮШ зуун
Хаана хадгалагдаж буй:	Эрдэнэзуу музей
Дурсгалын шинж байдал:	Зэс цутгамал, алт шармал 21.7 x 15.5 x 10 см
Дансны дугаар:	1/20 65/520

202.

Дурсгалын нэр:	Аюуш
Зохиогч:	Нэр үл мэдэгдэх урчууд
Бүтээсэн он цаг:	ХҮШ зуун
Хаана хадгалагдаж буй:	Эрдэнэзуу музей
Дурсгалын шинж байдал:	Мөнгө, алт шармал 24 x 14 x 10 см
Дансны дугаар:	1/3 65/309

203.

Дурсгалын нэр:	Юм Сэргиймаа
Зохиогч:	Нэр үл мэдэгдэх урчууд
Бүтээсэн он цаг:	ХҮШ зуун
Хаана хадгалагдаж буй:	Эрдэнэзуу музей
Дурсгалын шинж байдал:	Зэс цутгамал, алт шармал 37.05 x 16 x 9.5 см
Дансны дугаар:	1/3 65/01

204.

Дурсгалын нэр:	Босоо Майдар
Зохиогч:	Г.Занабазарын сургууль
Бүтээсэн он цаг:	ХҮШ зуун
Хаана хадгалагдаж буй:	Эрдэнэзуу музей
Дурсгалын шинж байдал:	Зэс цутгамал, алт шармал 37.5 x 16 x 9.5 см
Дансны дугаар:	2/87 65/59

205.

Дурсгалын нэр:	Дорж Сэмбэ
Зохиогч:	Нэр үл мэдэгдэх урчууд
Бүтээсэн он цаг:	ХҮШ зуун
Хаана хадгалагдаж буй:	Эрдэнэзуу музей
Дурсгалын шинж байдал:	Гууль цутгамал, алт шармал 18 x 12 x 12 см
Дансны дугаар:	4/35 65/02

206.

Дурсгалын нэр:	Дүйнхор
Зохиогч:	Нэр үл мэдэгдэх урчууд
Бүтээсэн он цаг:	ХҮШ зуун
Хаана хадгалагдаж буй:	Эрдэнэзуу музей
Дурсгалын шинж байдал:	Гууль цутгамал, алт шармал 60 x 30.5 x 30 см
Дансны дугаар:	1/58 65/536

207.
 Дурсгалын нэр: Сосорбарам
 Зохиогч: Нэр үл мэдэгдэх урчууд
 Бүтээсэн он цаг: ХҮШ зуун
 Хаана хадгалагдаж буй: Эрдэнэзуу музей
 Дурсгалын шинж байдал: Зэс цутгамал, алт шармал 18 x 14 x 9.5 см
 Дансны дугаар: 2/75 65/517
208.
 Дурсгалын нэр: Ямандаг
 Зохиогч: Нэр үл мэдэгдэх урчууд
 Бүтээсэн он цаг: ХҮШ зуун
 Хаана хадгалагдаж буй: Эрдэнэзуу музей
 Дурсгалын шинж байдал: Зэс цутгамал, алт шармал 17 x 14 x 0.7 см
 Дансны дугаар: 2/96 65/540
209.
 Дурсгалын нэр: Санжаа марлий зод
 Зохиогч: Нэр үл мэдэгдэх урчууд
 Бүтээсэн он цаг: ХҮШ зуун
 Хаана хадгалагдаж буй: Эрдэнэзуу музей
 Дурсгалын шинж байдал: Зэс цутгамал, алт шармал 23 x 16.5 x 11 см
 Дансны дугаар: 1/23 65/592
210.
 Дурсгалын нэр: Бурхан багш
 Зохиогч: Г.Занабазарын сургууль
 Бүтээсэн он цаг: XIX зуун
 Хаана хадгалагдаж буй: Эрдэнэзуу музей
 Дурсгалын шинж байдал: Зэс цутгамал, алт шармал 19 x 9.5 x 14 см
 Дансны дугаар: 2/9 65/350
211.
 Дурсгалын нэр: Авид
 Зохиогч: Г.Занабазарын сургууль
 Бүтээсэн он цаг: ХҮП зууны сүүлч
 Хаана хадгалагдаж буй: Эрдэнэзуу музей
 Дурсгалын шинж байдал: Зэс цутгамал, алт шармал 15 x 10 см
 Дансны дугаар: 1/48 65/932
212.
 Дурсгалын нэр: Манал
 Зохиогч: Г.Занабазарын сургууль
 Бүтээсэн он цаг: ХҮП зууны сүүлч
 Хаана хадгалагдаж буй: Эрдэнэзуу музей
 Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал 18 x 14 x 9 см
 Дансны дугаар: 1/36 65/919
213.
 Дурсгалын нэр: Ловон Бадамжунай
 Зохиогч: Г.Занабазарын сургууль
 Бүтээсэн он цаг: ХҮП зууны сүүлч
 Хаана хадгалагдаж буй: Эрдэнэзуу музей
 Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал 44 x 34 x 34 см
 Дансны дугаар: 1/64 65/353
214.
 Дурсгалын нэр: Лувсанчойжижанцан
 Зохиогч: Г.Занабазарын сургууль
 Бүтээсэн он цаг: ХҮП зууны сүүлч
 Хаана хадгалагдаж буй: Эрдэнэзуу музей
 Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал 25 x 12 x 12 см
 Дансны дугаар: 3/28 65/905

215.

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээсэн он цаг:
Хаана хадгалагдаж буй:
Дурсгалын шинж байдал:
Дансны дугаар:

Пагва лам
Г.Занабазарын сургууль
ХИХ зуун
Эрдэнэзуу музей
Зэс цутгамал, алт шармал 20.5 x 9 см
1/71 65/586

216.

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээсэн он цаг:
Хаана хадгалагдаж буй:
Дурсгалын шинж байдал:
Дансны дугаар:

Пагва лам
Нэр үл мэдэгдэх урчууд
ХҮШ зуун
Эрдэнэзуу музей
Зэс цутгамал, алт шармал 18 x 12 x 9.5 см
3/72 65/587

217.

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээсэн он цаг:
Хаана хадгалагдаж буй:
Дурсгалын шинж байдал:
Дансны дугаар:

Балдан Барнавын суварга
Г.Занабазарын сургууль
ХҮШ зуун
Эрдэнэзуу музей
Зэс цутгамал, алт шармал 37 x 23 x 23 см
1/06

218.

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээсэн он цаг:
Хаана хадгалагдаж буй:
Дурсгалын шинж байдал:
Дансны дугаар:

Няндай суварга
Нэр үл мэдэгдэх урчууд
ХҮШ зуун
Эрдэнэзуу музей
Зэс цутгамал, алт шармал 17 x 9.5 x 9.5 см
2/59 65/64

219, 220, 221, 222, 223, 224, 225.

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээсэн он цаг:
Хаана хадгалагдаж буй:
Дурсгалын шинж байдал:
Дансны дугаар:

Сэмбэжэд
Нэр үл мэдэгдэх урчууд
Тодорхойгүй
Эрдэнэзуу музей
Лим цутгамал 19.5 x 8 x 8 см, 7 ширхэг
3/22 65/30

226, 227.

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээсэн он цаг:
Хаана хадгалагдаж буй:
Дурсгалын шинж байдал:
Дансны дугаар:

Төрийн долоон эрдэнийн тахил, Өлзийт найман тахил
Нэр үл мэдэгдэх урчууд
Тодорхойгүй
Эрдэнэзуу музей
Зэс хөөмөл, алт шармал 64 x 24 см
1/92 65/1162

228.

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээсэн он цаг:
Хаана хадгалагдаж буй:
Дурсгалын шинж байдал:
Дансны дугаар:

Богд хаант Монгол Улсын төрийн далбаа
Нэр үл мэдэгдэх урчууд
ХИХ зуун
Үндэсний түүхийн музей
Шар, улаан өнгийн торго, соёмбо хатгасан 2.82 x 1.05 см

МОНГОЛУЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

А.ЦАНЖИД



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 26 -ны өдөр

Дугаар 123

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Ж.Гуррагчаа, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт зөвшөөрсүгэй.

1. "Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

3. "Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох тухай" Засгийн газрын 2001 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 261 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс энэ журмын дагуу олгохыг Батлан хамгаалахын сайд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД

Ж.ГУРРАГЧАА

*Засгийн газрын 2004 оны
123 дугаар тогтоолын хавсралт*

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ОФИЦЕР, АХЛАГЧ, ГЭРЭЭТ ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИД АЛБАН АЖЛЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Төрийн албаны тухай хуулийн 28.2.3-т заасныг үндэслэн зэвсэгт хүчинд цэргийн жинхэнэ алба хааж байгаа офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчдад өдөр, шөнө, улирлын ямарч нөхцөлд байлдааны жижүүрлэлт хийх, харуулд гарах, олон улсын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаа, хээрийн сургууль, дадлагад оролцох, байлдааны зэвсэг техник, тэсэрч дэлбэрэх болон хорт бодис, цэргийн нууцтай байнга харьцах, гамшгийн аюулгаас хүн ам, эд юмсыг авран хамгаалах болон тогтоосон хорио, цээрийн дэглэмийг сахиулахад туслах зэрэг онцгой үүрэг гүйцэтгэхэд албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоход энэхүү журмыг баримтална.

гэрээт цэргийн албан хаагчдад-ерөнхий зориулалтын болон хил, дотоодын цэргийн офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид хамаарна.

2. Энэ журмын 1-д заасан зэвсэгт хүчинд цэргийн жинхэнэ алба хааж байгаа офицер, ахлагч,

3. Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 10 хувиар тооцож сар бүр олгоно.

4. Энэ журмын 2-т заасан офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай байх хугацаанд нь олгохгүй.

5. Энэ журмын дагуу олгох албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн анги, салбарын төсвөөс гаргана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 26 -ны өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Д.Нацагдоржийн нэрэмжит шагналыг шилдэг бүтээл туурвиж монголын утга зохиолын хөгжил, ард түмнээ соён гэгээрүүлэх үйлсэд чухал хувь нэмэр оруулсан зохиолч, яруу найрагч, шүүмжлэгч нарт олгож байсугай.

бүрэлдэхүүн, уг шагналыг олгох журмын тухай" Засгийн газрын 1993 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал олгох журмыг хавсралт ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

3. Энэ тэгтгэл гарсантай холбогдуулан "Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал эрхлэх комиссын

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЬ: САЙД

А.ЦАНЖИД

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шилдэг зохиол, бүтээл туурвиж Монголын утга зохиолын хөгжил, ард түмнээ соён гийгүүлэх үйлсэд жинтэй хувь нэмэр оруулсан зохиолч, яруу найрагч, орчуулагч, шүүмжлэгч нарт болон Монголын уран зохиолыг гадаадад сурталчлахад тодорхой хувь нэмэр оруулсан гадаадын иргэнд Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал олгох үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Шагнал нь Д.Нацагдоржийн дүр бүхий тэмдэг, гэрчилгээ, мөнгөн шагнал байна. Мөнгөн шагналын хэмжээ 100000 (нэг зуун мянган) төгрөг байна.

Хоёр. Комиссын үйл ажиллагаа

2.1. Д.Нацагдоржийн нэрэмжит шагналд нэр дэвшигдсэн бүтээлд үнэлгээ өгөх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус комиссын бүрэлдэхүүнийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хоёр жилийн хугацаагаар батална.

2.2. Комисс нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, зохиолчдын байгууллага, зохиолч, судлаач, шүүмжлэгч, эрдэмтдийн төлөөллөөс бүрдсэн долоогоос доошгүй гишүүнтэй байна.

2.3. Комиссын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2.4. Комиссын нийт гишүүдийн дөрөвний гурваас доошгүй хувь нь хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцож,

хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос дээш хувийн саналаар дүгнэлт гаргана.

2.5. Хуралдаанд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурснаар комиссын дүгнэлт нь баталгаажна.

2.6. Комиссын гишүүний өөрийн бүтээл нь шагналд нэр дэвшигдэж байгаа тохиолдолд тухайн гишүүн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй.

Гурав. Шагналд нэр дэвшигдсэн бүтээлийг хэлэлцэх, шагнал олгох

3.1. Д.Нацагдоржийн нэрэмжит шагналаар шагнуулахаар зохиолч, яруу найрагч, орчуулагч, шүүмжлэгчдийн нэрийг зохиол, бүтээлийн хамт зохиолчдын эвлэл, холбоо, уран бүтээлийн байгууллагын хамт олноос дэвшүүлж, холбогдох материалыг тухайн оны 8 дугаар сарын 1-ний дотор комисст ирүүлнэ.

3.2. Комиссоос гаргасан дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал олгох шийдвэр гаргана.

3.3. Шагналыг хоёр жилд нэг удаа 3 хүртэл зохиолч, яруу найрагч, орчуулагч, шүүмжлэгчид их зохиолчийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан олгоно.

3.4. Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал хүртэгсдийн бүртгэл, судалгааны сан нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хадгалагдана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

 2004 оны 5 дугаар
 сарын 26 -ны өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

Хорио цээрийн дэглэм, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг цуцлах тухай

Сүхбаатар аймгийн зарим сумын нутагт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний голомтыг устгах арга хэмжээ болон халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын үр дүн, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг харгалзан Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай

хуулийн 11.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Наран сумын нутаг дэвсгэрт тогтоосон хорио цээрийн



хязгаарлалтын дэглэм, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг 5 дугаар сарын 26-ны өдрөөс цуцалсугай.

тооцсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Малын гоц халдварт өвчний цагийн байдалтай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 104 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД

Д.НАСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар
сарын 26 -ны өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

Хамгаалалтын бүс тогтоох тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.6-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэрт оршдог Баруун хүрээний туурийн хамгаалалтын бүсийг 220 га, Булган аймгийн Рашаант сумын нутаг дэвсгэрт оршдог Хөгнө тарнийн дээд, доод хийдийн туурийн хамгаалалтын бүсийг 42.9 га газар байхаар тус тус тогтоож, хамгаалалтын бүсийн хилийн цэгүүдийн геодезийн солбицлыг хавсралт ёсоор баталсугай.

хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулах, хамгаалалтын бүсэд барилга байгууламж барихыг хориглох арга хэмжээ авахыг дээрх аймгуудын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

А.ЦАНЖИД

Засгийн газрын 2004 оны 126 дугаар
тогтоолын хавсралт

ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ХИЛИЙН ЦЭГҮҮД (Солбицлын жагсаалт)

Цэгийн дугаар	Байршил	Геодезийн солбицол	
		х	у
1	Өвөрхангай аймгийн Хархоринт сум. Баруун хүрээний туурь	47°04'00	102°57'50
2		47°04'20	102°58'40
3		47°03'27	102°59'30
4		47°03'02	102°58'37
1	Булган аймгийн Рашаант сум. Хөгнө тарнийн дээд хийдийн туурь	47°26'09	103°42'20
2		47°26'21	103°42'20
3		47°26'21	103°42'45
4		47°26'09	103°42'45
1	Булган аймгийн Рашаант сум. Хөгнө тарнийн доод хийдийн туурь	47°25'22	103°41'28
2		47°25'32	103°41'28
3		47°25'40	103°41'54
4		47°25'22	103°41'54

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12.
Төрийн ордон
☎ 329612

Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

Хэвлэлийн хуудас 1.5